

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цэцэг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн
нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/14/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Улаанбаатар хот
2022 он

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Аудитор: Б.Должинжав

Утас: 70432545

цахим хаяг: narantuul.d@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	6
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	16
3.8 Аудитын гол асуудал	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
4. Аудитын илрүүлэлт.....	17
4.1 Залруулсан алдаа	17
4.2 Төлбөрийн акт.....	18
4.3 Албан шаардлага	
4.4 Зөвлөмж	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Ст
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НА	Нотлох ажил
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СХС	Сум хөгжүүлэх сан
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт -1	Санхүүгийн байдлын тайлан	10
Хүснэгт -2	Авлагын үлдэгдэл	10
Хүснэгт -3	Төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл	12
Хүснэгт -4	Татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл	12
Хүснэгт -5	Аудитад хамрагдсан байгууллагын алдаа, зөрчлийн нэгтгэл	
Хүснэгт -6	Түүвэрт хамрагдсан байгууллагын алдаа, зөрчлийн нэгтгэл	



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

ЦЭЦЭГ СУМЫН ЗАСАГ ДАГА
Ж.МӨНХЗОРИГ ТАНАА

2022.03.24 № 2/124
танай _____ -ны № _____ -т

ХЯЗГААРЛАЛТАЙ ДҮГНЭЛТ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Цэцэг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Цэцэг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль, журамд нийцүүлэн төлөвлөж, зарцуулаагүй, сум хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн авлагад алданги тооцоогүй, хугацаа хэтэрсэн зээлийн авлага барагдуулахад анхаарч ажиллаагүй, нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь авлагын дансанд он дамжсан, эзэн холбогдогч нь тодорхойгүй, тооцооны үлдэгдлээр баталгаажаагүй авлага бүртгэгдсэн, зардлыг ангилал хооронд нь гүйлгэн зарцуулснаар мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийн тайлан буруу тайлагнасан, сумын Засаг даргын Тамгын газрын санхүүгийн үйл ажиллагаанд хэрэгжүүлэх хяналт, санхүүгийн удирдлага, зохион байгуулалт сул, төсвийн төвлөрүүлэн захирагчийн шилэн дансны цахим систем дэх мэдээлэл хангалтгүй зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль холбогдох бусад хууль, журамтай нийцээгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн тохиолдолд дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан**

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,215,826.7	1,436,571.8
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	616,942.6	794,809.6
33	АВЛАГА	412,239.6	410,901.4
34	УРЬДЧИЛГАА	564.4	0.0
35	БАРАА МАТЕРИАЛ	186,080.0	230,860.8
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	9,899,882.2	12,691,088.7
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	9,899,882.2	12,691,088.7
39200	Биет хөрөнгө	9,822,388.0	12,614,137.3
39300	Биет бус хөрөнгө	77,494.2	76,951.5
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	11,115,708.9	14,127,660.6
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	54,377.5	28,853.3
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	54,377.5	28,853.3
41300	Өглөг	54,377.5	28,853.3
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	11,061,331.3	14,098,807.2
51	Засгийн газрын хувь оролцоо	11,061,331.3	14,098,807.2
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,079,824.1	2,079,824.1
51200	Хуримтлагдсан үр дүн	6,885,037.0	9,922,513.0
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,096,470.2	2,096,470.2
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	11,115,708.9	14,127,660.6

2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	7,972,522.6	7,165,145.0
11	ТАТВАРЫН ОРЛОГО	77,119.9	463,450.6
110	Орлогын албан татвар	63,062.6	55,182.3
1100	Хувь хүний орлогын албан татвар	63,062.6	55,182.3
113	Хөрөнгийн албан татвар	1,050.0	37,132.6
118	Бусад татвар, төлбөр, хураамж	13,007.4	371,135.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,515,820.4	3,838,282.4
120	Нийтлэг татварын бус орлого	4,515,820.4	3,834,694.4
121	Хөрөнгийн орлого	0.0	3,588.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,379,582.3	2,863,412.0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,977,178.2	4,082,246.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,977,178.2	3,947,129.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,089,427.3	3,755,745.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,685,084.4	1,782,905.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	214,880.3	235,532.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	238,023.3	257,538.8
2104	Хангамж, бараа материалын зардал	393,086.5	577,453.2
2105	Нормативт зардал	114,951.3	221,633.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,589.9	14,063.2
2107	Томиллолт, зочны зардал	3,140.0	8,043.0

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26,058.9	43,839.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	409,612.7	614,736.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	887,750.9	191,384.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.0	135,116.2
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	3,995,344.4	3,082,899.0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	15,226.9	3,015.7
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	3,980,117.5	3,079,883.3

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,094,363.8	7,094,363.8
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-13,150.0	-13,150.0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,081,213.9	7,081,213.9
9	Тайлант үеийн үр дүн	3,980,117.5	3,980,117.5
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	11,061,331.3	11,061,331.3
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	11,061,331.3	11,061,331.3
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-42,407.4	-42,407.4
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	11,018,924.0	11,018,924.0
19	Тайлант үеийн үр дүн	3,079,883.3	3,079,883.3
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	14,098,807.2	14,098,807.2

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	3,666,938.7	3,794,901.5
11	ТАТВАРЫН ОРЛОГО	77,119.9	463,450.6
110	Орлогын албан татвар	63,062.6	55,182.3
1100	Хувь хүний орлогын албан татвар	63,062.6	55,182.3
113	Хөрөнгийн албан татвар	1,050.0	37,132.6
118	Бусад татвар, төлбөр, хураамж	13,007.4	371,135.7
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	8,939.8	55,409.3
1181	Газрын төлбөр	1,793.9	3,519.4
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	2,273.6	312,207.1
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	210,236.5	498,639.1
120	Нийтлэг татварын бус орлого	210,236.5	495,051.1
121	Хөрөнгийн орлого	0.0	3,588.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,379,582.3	2,832,811.8
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,393,234.5	2,991,897.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,393,234.5	2,991,897.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,500,956.9	2,795,035.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,655,279.3	1,795,028.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	223,236.3	232,560.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	236,926.1	292,804.3
2104	Хангамж, бараа материалын зардал	65,677.7	87,742.4
2105	Нормативт зардал	124,261.6	227,647.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,647.6	7,074.3
2107	Томилолт, зочны зардал	3,140.0	8,043.0

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	25,537.6	32,432.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	160,250.6	111,702.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	892,277.6	196,862.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	273,704.2	803,004.2
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	350,774.1	611,937.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	350,774.1	611,937.2
2200	Дотоод эх үүсвэрээр	350,774.1	611,937.2
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-350,774.1	-611,937.2
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0.0	-13,200.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0.0	13,200.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-77,069.9	177,867.0
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	694,012.5	616,942.6
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	616,942.6	794,809.6

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,436,434,600.00	3,145,457,451.34	-
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,545,725,900.00	2,520,320,287.34	290,977,148.66
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,442,794,600.00	2,417,388,987.34	-25,405,612.66
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,718,142,300.00	1,695,660,148.04	-22,482,151.96
210101	Үндсэн цалин	1,134,687,100.00	1,121,724,800.43	-12,962,299.57
210102	Нэмэгдэл	432,512,800.00	431,380,965.90	-1,131,834.10
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,544,000.00	4,948,915.00	-595,085.00
210104	Урамшуулал	93,198,700.00	89,648,756.10	-3,549,943.90
210105	Гэрээт ажлын хөлс	52,199,700.00	47,956,710.61	-4,242,989.39
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	232,286,800.00	232,263,550.00	-23,250.00
210201	Тэтгэврийн даатгал	163,251,400.00	163,228,150.00	-23,250.00
210202	Тэтгэмжийн даатгал	17,184,500.00	17,184,500.00	0.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,747,300.00	13,747,300.00	0.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,437,800.00	3,437,800.00	0.00
210205	Эрүүл мэндийн даатгал	34,665,800.00	34,665,800.00	0.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	259,141,200.00	258,822,333.30	-318,866.70
210301	Гэрэл, цахилгаан	19,441,200.00	19,162,633.30	-278,566.70
210302	Түлш, халаалт	237,553,600.00	237,513,300.00	-40,300.00
210303	Цэвэр, бохир ус	2,146,400.00	2,146,400.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	62,044,500.00	62,010,300.00	-34,200.00
210401	Бичиг хэрэг	4,961,900.00	4,961,900.00	0.00
210402	Тээвэр, шатахуун	46,364,700.00	46,364,700.00	0.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,240,400.00	6,240,400.00	0.00
210404	Ном, хэвлэл	398,700.00	364,500.00	-34,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,705,300.00	2,705,300.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,373,500.00	1,373,500.00	0.00
2105	Нормативт зардал	87,262,700.00	87,199,500.00	-63,200.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	22,156,700.00	22,098,400.00	-58,300.00

210502	Хоол, хүнс	60,712,900.00	60,708,000.00	-4,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,393,100.00	4,393,100.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,290,000.00	6,290,000.00	0.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,000,000.00	1,000,000.00	0.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	267,000.00	267,000.00	0.00
210604	Урсгал засвар	5,023,000.00	5,023,000.00	0.00
2107	Томилолт, зочны зардал	6,800,600.00	6,245,300.00	-555,300.00
210702	Дотоод албан томилолт	6,800,600.00	6,245,300.00	-555,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	25,483,800.00	23,983,606.00	-1,500,194.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	22,202,800.00	20,702,746.00	-1,500,054.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,973,000.00	1,973,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	445,000.00	445,000.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	155,000.00	154,860.00	-140.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	110,000.00	110,000.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	475,000.00	475,000.00	0.00
210807	Газрын төлбөр	123,000.00	123,000.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	45,342,700.00	44,914,250.00	-428,450.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	35,765,900.00	35,672,900.00	-93,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,576,800.00	9,241,350.00	-335,450.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	102,931,300.00	102,931,300.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	102,931,300.00	102,931,300.00	0.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	40,421,700.00	40,421,700.00	0.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	29,662,600.00	29,662,600.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	32,847,000.00	32,847,000.00	0.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	830,708,700.00	611,937,164.00	218,771,536.00
220001	Барилга байгууламж	512,500,000.00	298,943,064.00	213,556,936.00
221001	Их засвар	92,123,200.00	86,908,600.00	-5,214,600.00
222001	Тоног төхөөрөмж	75,000,000.00	75,000,000.00	0.00
223001	Бусад хөрөнгө	151,085,500.00	151,085,500.00	0.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	60,000,000.00	13,200,000.00	-46,800,000.00
230001	Эргэж төлөгдөх зээл	60,000,000.00	13,200,000.00	-46,800,000.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,436,434,600.00	3,234,567,499.34	201,867,100.66
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,713,543,700.00	1,713,538,800.00	-4,900.00
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,713,543,700.00	1,713,538,800.00	-4,900.00
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,108,510,100.00	1,059,828,011.34	-48,682,088.66
320001	Орон нутгийн төсвөөс	980,524,600.00	931,842,517.34	-48,682,082.66
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	127,985,500.00	127,985,494.00	-6.00
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	33,875,800.00	22,646,370.00	-11,229,430.00

330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	33,875,800.00	22,646,370.00	-11,229,430.00
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	580,505,000.00	438,554,318.00	141,950,682.00
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	605,000.00	605,000.00	0.00
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	576,800,000.00	437,949,318.00	138,850,682.00
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	3,100,000.00	0	-3,100,000.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	439,454,151.60	439,454,151.60
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	528,494,199.60	528,494,199.60
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	1,085	1,085	0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	6	6	0
610001	Төсвийн байгууллага	6	6	0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	144	144	0
620001	Удирдах ажилтан	13	13	0
620002	Гүйцэтгэх ажилтан	84	84	0
620003	Үйлчлэх ажилтан	36	36	0
620004	Гэрээт ажилтан	11	11	0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	380411355.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	380411355.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	325567637.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	93554484.0
210101	Үндсэн цалин	10400000.0
210102	Нэмэгдэл	83154484.0
2104	Хангамж, бараа материалын зардал	14563112.0
210401	Бичиг хэрэг	2547200.0
210402	Тээвэр, шатахуун	1000000.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	11015912.0
2105	Нормативт зардал	140448189.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	124288431.0
210502	Хоол, хүнс	16159758.0
2107	Томилолт, зочны зардал	1797724.0
210702	Дотоод албан томилолт	1797724.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8415669.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8415669.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	66788459.1
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	66488459.1
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	300000.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	54843718.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	54680718.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	25880718.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	28800000.0
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	163000.0

213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	163000.0
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	380411355.1
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	380411355.1
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	47180914.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	64992092.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	20443009.1
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	247795340.0

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Цэцэг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь авлага, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагнал, татварын орлогын төлөвлөлт, түүвэрт хамрагдсан ЗДТГ, ИТХ, Соёлын төв, ОНХС-ийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүдэд өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг аудитор Б.Должинжав 2022 оны 3 дугаар сарын 17-ноос 2022 оны 03 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Цэцэг сумын Засаг дарга 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 3 дугаар сарын 22-ны өдөр 2022.02.21-ны 1/16 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Цэцэг сумын засаг дарга нь Монгол улсын Үндсэн хууль болон УИХ, Засгийн газраас гарч буй хууль тогтоомжид нийцүүлэн “Төрийн албан хаагчдыг чадавхижуулж, иргэдэд ил тод, тэгш хүртээмжийг бий болгож, орон нутгийн хөгжлийг цогцлоон бий болгоход оршино” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд үйл ажиллагааны стратегийн зорилтыг “Бүх шатанд стандартын хэм хэмжээг нэвтрүүлсэн, бие даасан эдийн засагтай, байгаль орчинд ээлтэй, хүний хөгжлөөр тэргүүлсэн сум болно” хэмээн тодорхойлж, "Алсын хараа-2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, "Аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл" сумын засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх 16 зорилтын хүрээнд 73 ажлыг 90 хувийн биелэлттэй хэрэгжүүлэн ажилласан байна.

Тайлант хугацаанд санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар “Төсвийн зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”
- Малын тоо толгойн албан татварын тухай хууль
- Нийгмийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай хууль
- Эрүүл мэндийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай хууль
- Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор “төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”

Удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөө багатай байна гэж үзлээ.

Сумын хэмжээнд тусгайлан баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй бөгөөд Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар батлагдсан санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журмын дагуу “цахим Э-тайлан” программ хангамж ашиглан санхүүгийн тайлан нэгтгэсэн байна.

Төсвийн 6 байгууллагаас 4 байгууллага НББ-ийн бодлогын баримт бичгийг боловсруулан батлуулж, санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байна.

2021 оны 4 дүгээр улиралд аймгийн Засаг даргын дэргэдэх санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас Цэцэг сумын Засаг даргын дэргэдэх төсвийн байгууллагууд, ОНХС,СХС, Хөшөөт хөгжлийн сангийн 2018-2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын гүйцэтгэсэн ажлын тайлан, дүн дүгнэлт эцэслэн гараагүй учир дотоод аудитаас туслалцаа авах, дүн мэдээг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цэцэг сумын ТТЗ-ын 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд түүвэрт хамруулан гүйцэтгэж буй субъектын ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлалтай гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд суурь үзүүлэлтээр батлагдсан төсвийг сонгож, эрсдэлийн үнэлгээнээс хамаарч материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “бага” гэж үнэлсэн учир материаллаг байдлын түвшинг хамгийн ихээр буюу 2 хувиар тогтоосон.

Материаллаг байдлын түвшинг 2021 оны батлагдсан төсөв 3436.4 сая төгрөгөөс 2 хувиар буюу 68.7 сая төгрөгөөр тооцож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 80 хувиар буюу 55.0 сая төгрөгөөр тогтоов.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Цэцэг сумын ТТЗ-ын 2021 оны нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3011.9 сая төгрөгөөр буюу 27 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө данстууд байна.

Хүснэгт №1. Санхүүгийн байдлын тайлан

/мянган төгрөг/

Тайлангийн үзүүлэлтүүд	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	
Мөнгөн хөрөнгө	616,942.6	794,809.6	177,867.00	129%
Авлага	412,239.5	410,901.4	-1,338.10	100%
Бараа материал	186,080.0	230,860.8	44,780.80	124%
Урьдчилгаа	564.4	0.0	-564.40	0%
Үндсэн хөрөнгө	9,899,882.2	12,691,088.7	2,791,206.50	128%
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	11,115,708.7	14,127,660.5	3,011,951.80	127%
Богино хугацаат өр төлбөр	54,377.5	28,853.3	-25,524.20	53%
Цэвэр хөрөнгө, өмч	11,061,331.2	14,098,807.2	3,037,476.00	127%
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	11,115,708.7	14,127,660.5	3,011,951.80	127%

Эх сурвалж: Цэцэг сумын ТТЗ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 616.9 сая төгрөг байсан бол оны эцэст 794.8 сая төгрөг болж 177.9 сая төгрөгөөр буюу 29 хувиар өссөн байна. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 794.8 сая төгрөгийн 791.2 сая төгрөг нь төрийн сангийн харилцах дансанд, 3.6 сая төгрөг нь Мянган сутайн буянт ОНӨҮГ-ын арилжааны банкин дахь харилцах дансанд байршиж байна.

Төрийн сангийн харилцах данс дахь мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг тодруулбал 262.7 сая төгрөг нь орон нутгийн ерөнхий орлогын дансанд, 473.9 сая төгрөг нь ОНХС-ийн дансанд, 54.6 сая төгрөг нь СХС-ийн дансанд тус тус үлдсэн байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 412.2 сая төгрөг байсан бол оны эцэст 410.9 сая төгрөг болж 1.3 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №02 Авлагын үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	24,783.50	27,721.3	2,937.8
Төлбөртэй үйлчилгээний авлага		36,259.6	36,259.6
Байгууллагаас авах авлага	130,306.60	87,198.5	(43,108.1)
Хувь хүмүүсээс авах авлага	88,250.00	95,527.3	7,277.3
Зээлийн хүүгийн авлага	164,372.7	164,194.7	(178.0)
Татаас санхүүжилтийн авлага	4,526.7		(4,526.7)
Дүн	412,239.5	410,901.4	(1,338.1)
Цалингийн урьдчилгаа	564.4		(564.4)
Дүн	564.4	-	(564.4)
АВЛАГЫН НИЙТ ДҮН	412,803.9	410,901.4	(1,902.5)

Эх сурвалж: Цэцэг сумын ТТЗ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны үлдэгдэл 410.9 сая төгрөг байгаагаас 197.9 сая төгрөгийн авлага нь он дамжсан, насжилт өндөртэй авлага ба үүнээс 13.1 сая төгрөг нь эзэн холбогдогч нь тодорхойгүй авлага байна. Мөн 85.3 сая төгрөгийн авлагын тооцоо нийлж үлдэгдлийн баталгаагаар баталгаажуулаагүй, 14.1 сая төгрөг НДШ, ХХОАТ-т цалингийн сангийн

хэмнэлтийг шилжүүлж авлага үүсгэсэн зэрэг зөрчлүүд байна.

Насжилт өндөртэй 197.9 сая төгрөгийн авлагын 145.2 сая төгрөг нь 36 иргэнтэй холбогдох СХС-ийн хугацаа хэтэрсэн зээлийн авлага байгаа ба шүүх, хууль хяналтын байгууллагад шилжүүлэн ажилласан ба орон нутгийн хөгжлийн сангаас 2019 онд олгосон жишиг хашааны 11 иргэнтэй холбоотой 22.3 сая төгрөгийн авлага барагдуулахад анхаарч ажиллаагүй байна.

3.5.3 Бараа материал

Бараа материал дансны оны эхний үлдэгдэл 186.1 сая төгрөг байсан бол оны эцэст 231.2 сая төгрөг болж 45.1 сая төгрөгөөр өссөний материаллаг нөлөө нь эм боох материалын данстай холбоотой байна.

Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 379.6 сая төгрөгийн бараа материал худалдан авч, үнэ төлбөргүйгээр 63.3 сая төгрөгийн бараа материал хүлээн авч, 312.3 сая төгрөгийн бараа материал үйл ажиллагаанд зарцуулж, 85.8 сая төгрөгийн бараа материал акталж данс бүртгэлээс хассан байна.

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 11319.7 сая төгрөг байсан бол оны эцэст 14576.9 сая төгрөг болж 3257.2 сая төгрөгөөр өсжээ. Энэ нь 3221.0 сая төгрөгийн хөрөнгө өмнө нь данс бүртгэлд тусгаагүй байсныг аймгийн ИТХ-ын 2021 оны 143, 188 дугаар тогтоолоор данс бүртгэлд тусган, 106.7 сая төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авч, 70.5 сая төгрөгийн хөрөнгө акталж данс бүртгэлээс хассан байна.

3.5.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн оны эхний үлдэгдэл 54.4 сая төгрөг байсан бол оны эцэст 29.0 сая төгрөг болж 25.4 сая төгрөгөөр буурсан байна. Өр төлбөрийн эцсийн үлдэгдэлд сум хөгжүүлэх сангийн 20.4 сая төгрөгийн өр төлбөр, ЕБС-ийн 3.2 сая төгрөгийн өр төлбөр, Соёлын төвийн 4.8 сая төгрөгийн өр төлбөр материаллаг нөлөө үзүүлж байгаа ба нийт өр төлбөрийн 97.9 хувийг эзэлж байна.

3.5.7 Цэвэр хөрөнгө, өмч

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 11061.3 сая төгрөг байсан бол оны эцэст 14098.8 сая төгрөг болж 3037.5 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 3079.9 сая төгрөг, өмнөх үеийн үр дүнд 42.4 сая төгрөгийн бууруулах залруулга хийсэнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 3305.8 сая төгрөгөөр, нийт зарлагыг 3305.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Цэцэг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны төсвийн нийт зарлагыг аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 03 өдрийн 3/03 тоот тогтоолоор 3401.2 сая төгрөгөөр анх баталж өмнө оны болон тайлант оны орлого давсан холбоотойгоор 2021 онд 1 удаа тодотгол хийн 2021 оны 08 дугаар сарын 05-ны 4/03 тоот тогтоолоор нийт 3436.4 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн тодотголыг сумын ИТХ-аар 2021 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн 23 дугаар тогтоолоор сумын нийт төсвийн орлого, зарлагыг баталсан боловч нэгтгэн товчоолж орлого, зардлын дүнг батлаагүй, хоорондоо зөрүүтэй, зарим зардлын дүнг тогтоолд тусгаагүй байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 3436.4 сая төгрөгийн төсөв баталснаас 1713.5 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 980.5 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 128.0 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас, 33.9 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 516.2 сая төгрөгийг хөшөөт хөгжил сангаас, 60.0 сая төгрөгийг сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс, 1.2 сая төгрөгийн төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогоос 3.1 сая төгрөгийг ОНХС-ийн урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Төсвийн төлөвлөгөө гүйцэтгэл Хүснэгт-3			/сая төгрөг/	
Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,436.4	3,234.6	-201.9	
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,713.5	1,713.5	0.0	
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,108.5	1,059.8	-48.7	
Орон нутгийн төсвөөс	980.5	931.8	-48.7	
Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	128.0	128.0	0.0	
НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	33.9	22.6	-11.2	
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	33.9	22.6	-11.2	
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	580.5	438.6	-142.0	
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.6	0.6	0.0	
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	576.8	437.9	-138.9	
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	3.1	0.0	-3.1	

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 1,713.5 сая, орон нутгийн төсвөөс 931.8 сая, орон нутгийн хөгжлийн сангаас 128.0 сая, эрүүл мэндийн даатгалын сангаас 22.6 сая, сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт 44.4 сая, хөшөөт хөгжил сангаас 349.8 сая, төсөвт байгууллагын өөрийн орлого 0.9 сая, давсан орлогоос ОНХС-д 43.5 сая нийт 3,234.6 сая төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдүүлж, төлөвлөснөөс 201.9 сая төгрөгийн дутуу гүйцэтгэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,145.5 сая төгрөг буюу 91.5 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 22.5 сая, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 0.3 сая, нормативт зардлыг 0.1 сая, томилт, зочны зардлыг 0.6 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 1.5 сая, Бараа үйлчилгээний бусад зардлыг 0.4 сая, хөрөнгийн зардлыг 218.8 сая, эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлийг 46.8 сая төгрөгөөр тус тус хэмнэж ажилласан байна.

Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар төлөвлөж, хуваарилах Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хянахад анхны батлагдсан төсвөөс 340.1 сая төгрөг хэмнэж төлөвлөх байтал тодотголоор 35.2 сая төгрөг нэмж төлөвлөсөн, харин нийт зардлаас 291.0 сая төгрөгийн хэмнэлт гарган ажилласнаас дүгнэхэд ЗГ-ын 43 дугаар тогтоол шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй байна.

Суурь орлогыг 112.5 хувиар буюу 105.4 сая төгрөгөөр давуулж, үүнээс татварын орлогыг 178.8 хувиар буюу 204.2 сая төгрөгөөр давуулж, татварын бус орлогыг 83 хувиар буюу 98.8 сая төгрөгөөр дутуу биелүүлжээ.

Хүснэгт 4. Сумын суурь орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая.төгрөг/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	СУУРЬ ОРЛОГО	841.6	947.1	105.4
11	ТАТВАРЫН ОРЛОГО	259.2	463.5	204.2

110	Орлогын албан татвар	39.5	55.2	15.7
1100	Хувь хүний орлогын албан татвар	39.5	55.2	15.7
110002	Үйл ажиллагааны орлого	4.0	19.5	15.5
110003	Хөрөнгийн орлого	22.0	29.5	7.5
110008	Шууд бус орлого	13.5	6.1	-7.4
113	Хөрөнгийн албан татвар	57.4	37.1	-20.2
113002	Бууны албан татвар	2.4	2.1	-0.3
113004	Малд ногдуулах албан татвар	55.0	35.0	-20.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	162.4	371.1	208.8
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	4.5	55.4	50.9
118001	Улсын тэмдэгтийн хураамж	2.5	53.1	50.7
118006	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	1.0	0.5	-0.5
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	1.1	1.8	0.8
1181	Газрын төлбөр	1.8	3.5	1.7
118101	Газрын төлбөр	1.8	3.5	1.7
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	156.1	312.2	156.1
118202	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	153.9	310.6	156.7
118203	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	1.1	1.1	0.1
118204	Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	1.1	0.4	-0.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	582.4	483.6	-98.8
120	Нийтлэг татварын бус орлого	582.4	483.6	-98.8
120003	Торгуулийн орлого	5.0	9.9	4.9
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	577.4	438.6	-138.9
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.6	0.6	0.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	576.8	437.9	-138.9
120009	Бусад орлого	0.0	35.2	35.2
121	Хөрөнгийн орлого	0.0	3.6	3.6
121001	Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	0.0	3.6	3.6

Эх сурвалж: Цэцэг сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Орлого давж биелэхэд материаллаг нөлөө үзүүлсэн нь ан амьтны нөөц ашигласны төлбөр хураамжийн орлого 156.7 сая, улсын тэмдэгтийн хураамжийн орлого 50.7 сая төгрөгөөр тус тус давж биелснээс шалтгаалжээ.

Дээрх орлого материаллаг хэмжээгээр давж биелсэн шалтгаан нь ангийн орлогын төлөвлөлтөөс гадна Байгаль орчин аялал жуулчлалын яамны тусгай зөвшөөрлөөр 5 угалз, 2 тэх агнуулан 310.6 сая төгрөгийн ангийн орлого, ан агнах тусгай зөвшөөрөлтэй холбоотой 48.7 сая төгрөгийн улсын тэмдэгтийн хураамжийн орлого бүрдсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар нийт 380.4 сая төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдүүлснээс 47.2 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 65.0 сая төгрөгийг дээд шатны байгууллагаас, 20.4 сая төгрөгийг төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого, 247.8 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас тус тус хууль, журамд нийцүүлэн орлогын эх үүсвэр бүрдүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн дансны орлогыг байгууллагаар задалбал ИТХ 0.2 сая, эрүүл мэндийн төв 279.8 сая, ЕБС 27.6 сая, хүүхдийн цэцэрлэг 13.9 сая, ЗДТГ 58.9 сая нийт 380.4 сая төгрөгийн орлогыг нэмэлт санхүүжилтийн дансаар хүлээн авч, 380.2 сая төгрөгийг зориулалтын дагуу холбогдох арга хэмжээнд зарцуулж, 0.2 сая төгрөгийг нэмэлт санхүүжилтийн татан төвлөрүүлэлтийн дансанд төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Цэцэг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд АДБОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй дараах асуудал байна. Үүнд:

- Цэцэг сум 2020 оны үйл ажиллагаагаар аймгийн тэргүүний сум, халамжаас хөдөлмөрт шилжсэн 2021 оны Ховд аймгийн анхдагч сумаар шалгарсан онцлогтой байна.
- ОНХС-ийн дансны үлдэгдэл дэх 473.9 сая төгрөгийн 320.0 сая төгрөг нь компаниудын хөрөнгө оруулалт хийхээр байршуулсан барьцаа хөрөнгө ба тухайн асуудал шүүхийн шатанд байна.
- Сум хөгжүүлэх сангаас 2011-2021 онуудад олгосон 44 зээлдэгчийн 229.5 сая төгрөгийн зээл олгогдсоноос 1 иргэн нас барсан боловч зээлийг үр хүүхдүүд нь төлж дууссан, 8 зээлдэгч зээлээ бүрэн төлж дууссан, 36 иргэний 164.2 сая төгрөгийн зээлийн авлага нь хугацаа хэтэрч байгаа нь сангийн хөрөнгийн эргэцийг удаашруулж, хөрөнгийн үр өгөөжийг бууруулж байна.
- Ковид 19 цар тахлаас урьдчилан сэргийлэх тэмцэхтэй холбоотой хувь иргэн, ААН, байгууллагуудаас 12.7 сая хөрөнгө оруулалт, 50.6 сая төгрөгийн бараа материал, нийт 63.3 сая төгрөгийн хандив цугларч 58.3 сая төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулжээ.
- Тайланд хугацаанд 755 хүн Ковид 19 цар тахлаар өвчилж 306.7 сая төгрөгийн нэг удаагийн эм, эмнэлгийн хэрэгсэл урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулсан байна.

3.8 Аудитын гол асуудал

Цэцэг сумын ТТЗ-ын нэгтгэсэн санхүүгийн тайланд Хөшөөт багт баригдсан соёлын төв, хүүхдийн цэцэрлэг, уурын зуух, гүний худаг, халуун ус, шугам сүлжээ зэрэг 3221.0 сая төгрөгийн өртөг бүхий барилга байгууламжийг тайлант онд аймгийн ИТХ-ын тогтоол шийдвэр гаргуулан данс бүртгэлд тусгасан нь тайлант оны үр дүн өсөхөд гол нөлөө үзүүлсэн байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим мэдээллийн системд төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайлант хугацаанд оруулбал зохих мэдээллийн иж бүрэн, үнэн зөв байдал хангалтгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 14.9 сая төгрөгийн төлбөрийн акт барагдуулаагүй, албан шаардлага болон зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн ханган ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

2020 онд ОНХС-ийн зарцуулалтад хийгдсэн гүйцэтгэлийн аудитын албан шаардлагын хэрэгжилт, Хөшөөт хөгжил сангийн 2021 оны 3, 4 дүгээр улирлын санхүүжилт нь тээвэр зогссоны улмаас ороогүй санхүүжилтийн авлага, өглөгийн хоорондын тооцоо, “Эрчим дөл”, ХХК- тай байгуулсан халаалт, концессын гэрээний нөхцөл зэргийг дараагийн аудитаар анхаарал хандуулах нь зүйтэй гэж үзлээ.

3.12 Харьяа байгууллагуудын аудитын дүнгийн талаар

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 6 төсвийн байгууллага, 2 тусгай сан, 1 ОНӨҮГ нийт 9 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 3 байгууллагыг аудитад хамруулан дүгнэлт гаргаж, 6 тайланг түүвэрт хамруулан хянасан байна.

Аудитад хамрагдсан байгууллагаас Эрүүл мэндийн төв, хүүхдийн цэцэрлэг буюу 2 байгууллага “Зөрчилгүй”, Ерөнхий боловсролын сургууль “Хязгаарлалттай” дүгнэлттэйгээр санхүүгийн тайланг аудитаар баталгаажуулсан байна.

Аудитын дүгнэлт гарсан байгууллагуудад нийт 154.0 сая төгрөгийн 17 алдаа зөрчил илэрч, 21.2 сая төгрөгийн 4 алдааг залруулсан байна.

Залруулагдаагүй 132.7 сая төгрөгийн алдаа зөрчлөөс 15.1 сая төгрөгийн алдаа зөрчилд 4 төлбөрийн акт тогтоон, 1.5 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгуулах 1 албан шаардлага, 116.1 сая төгрөгийн 8 зөрчилд зөвлөмж өгөгдсөн байна.

Аудитад хамрагдсан байгууллагын алдаа, зөрчлийн нэгтгэл : Хүснэгт-5 /сая төгрөг/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ЕБС	7	108.3			3	6.3	1	1.5	3	100.5
2	СӨБ	2	15.6							2	15.6
3	ЭМТ	8	30.0	4	21.2	1	8.8			3	-
	Дүн	17	154.0	4	21.2	4	15.1	1	1.5	8	116.1

Эх сурвалж: Цэцэг сумын ТШЗ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

4. Нэгтгэсэн тайлангийн аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 701.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 125.8 сая төгрөгийн 5 алдаа, зөрчлийг залруулж, 29.8 сая төгрөгийн 4 зөрчилд төлбөрийн акт, 236.5 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 албан шаардлага, 309.0 сая төгрөгийн 7 зөрчилд зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- ОНХС-ийн жишиг хашааны 2021 онд төлөгдсөн 5.2 сая төгрөгийн авлага бууруулж бүртгээгүй.
- СХС-ийн 20.4 сая төгрөгийн зээлийн авлага дутуу бүртгэсэн.

3. Өмнөх онд ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн данснаас төвлөрүүлж авлагаар бүртгэгдсэн газрын төлбөрийн дуудлага худалдааны 35.2 сая төгрөгийн авлага илүү бүртгэсэн байна.
4. ЗДТГ, ИТХ шилэн дансны цахим системд оруулбал зохих мэдээллийн тоо, дүн мэдээг дутуу байршуулсан.
5. ЗДТГ үнэ төлбөргүй хүлээн авсан 98.8 сая төгрөгийн хөрөнгө данс бүртгэлд тусгаагүй, 1.3 сая төгрөгийн хөрөнгийг актлах тогтоол шийдвэр гарсан боловч данс бүртгэлээс хасаагүй, түүнчлэн үндсэн хөрөнгийн тооллогын бүртгэл тооцоо, санхүүгийн баримт бичгийн бүрдэл хангалтгүй зэрэг алдаа зарчлийг аудитын явцад залрууллаа.

Шийдвэрлэсэн нь: Нийт 60.8 сая төгрөгийн бүртгэлийн алдаа, зөрчлийг шалгагдагч байгууллагад танилцуулан 2022 оны 03 дүгээр сарын 25-ны 1/16, 1/17 тоот албан бичгээр санхүүгийн тайланд залруулга хийсэн болно.

4.2 Төлбөрийн акт

4.2.1 Илрүүлэлт: Сумын ЗДТГ Хамтарсан багаас зохион байгуулсан арга хэмжээний шагнал олгоходоо хувь хүний орлогын албан татварын 10 хувийн ашиг ногдуулаагүй 192.0 мянган төгрөг, Засаг даргын орлогчид анхан шатны баримтаар нотлохгүй бүрэн бус, томилолтын хуудасгүй албан томилолт олгосон 114.0 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

4.2.2 Илрүүлэлт: Сумын ЗДТГ цалингийн сангийн хэмнэлт 8554.3 мянган төгрөгийг оны эцэст НДШ, ХХОАТ-т илүү шилжүүлж авлага үүсгэсэн.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

4.2.3. Илрүүлэлт: Сумын ИТХ цалингийн сангийн хэмнэлт 617.9 мянган төгрөгийг оны эцэст НДШ-д илүү шилжүүлж авлага үүсгэсэн.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

4.2.4. ОНХС-аас 2 иргэнд 20.0 сая төгрөгийн эргэж төлөгдөх нөхцөлтэй зээл олгосон.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

4.3 Албан шаардлага

4.3.1 Илрүүлэлт: Орон нутгийн хөгжлийн сангаас 5 багийн 5 өрхөд гэр олгоход 17.5 сая, иргэдээс санал аваагүй хөтөлбөр арга хэмжээ буюу иргэдийн төлөөлөгч нарыг чадавхжуулах зардалд 10.0 сая, өвс тэжээлийн фонд бэлтгэхэд 20.0 сая, Ковид-19 вирусийн тархалт, дэгдэлтээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 9.0 сая, түүнчлэн хөшөөт багийн барилга байгууламжийн байр ашиглалтын тогтмол зардал, гэрээт ажилчдын цалин хөлсний зардалд буюу урсгал зардлыг санхүүжүүлэхэд 34.8 сая төгрөгийг төлөвлөж зарцуулсан нь орон нутгийн хөгжлийн сангийн журам, зорилгод нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 4 дүгээр зүйлд нийцээгүй тул албан шаардлага өгөв.

Илрүүлэлт: 4.3.2 Шилэн дансны цахим мэдээллийн системд төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайлант хугацаанд оруулбал зохих зарим мэдээллийг цаг хугацаанд нь иж бүрэн, үнэн зөв мэдээлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 4, 6 дугаар зүйлд нийцээгүй тул албан шаардлага өгөв.

Илрүүлэлт: 4.3.3 Сум хөгжүүлэх сангийн 145.2 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн авлагад алданги тооцоогүй, зээл авсан иргэдтэй тооцоо нийлж үлдэгдлээ баталгаажуулаагүй, түүнчлэн ИТХ-аас СХС-ийн үйл ажиллагаанд ажлын хэсэг томилж

хяналт хэрэгжүүлээгүй, сангийн үйл ажиллагаа нь сум хөгжүүлэх сангийн зорилго, журамд нийцэж буй эсэх нь тодорхойгүй байна.

Шийдвэрлэсэн нь : Сум хөгжүүлэх сангийн зорилго, журамд нийцээгүй тул албан шаардлага өгөв.

4.4. Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

4.4.1 Нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь авлагын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн авлага дансны үлдэгдэл 410.9 сая төгрөг байгаагаас 197.9 сая төгрөгийн авлага нь он дамжсан, насжилт өндөртэй авлага ба үүнээс 13.1 сая төгрөг нь эзэн холбогдогч нь тодорхойгүй авлага байна. Мөн 85.3 сая төгрөгийн авлагын тооцоо нийлж үлдэгдлийн баталгаагаар баталгаажуулаагүй зөрчил байна.

Өгсөн зөвлөмж Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан нягтлан бодогчийн эрх, үүргийн хүрээнд сумын нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь төсөвт байгууллага, төсөл сангийн он дамжсан, насжилт өндөртэй эзэн холбогдогч тодорхойгүй авлагын хариуцагчийг тодорхойлж барагдуулахад чиглүүлэн удирдлага арга зүйгээр хангаж, үе шаттай арга хэмжээ хэрэгжүүлж ажиллах.

4.4.2 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Харьяа төсвийн байгууллагууд нь цалингийн зардлыг бодитой төлөвлөөгүй, түүнчлэн бүртгэл тооцооны хяналт суларснаас шалтгаалж цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлыг бүлэг дотроо ангилал хооронд, мөн цалингийн зардлыг нийгмийн даатгалын шимтгэлийн зардалтай гүйлгэн зарцуулдаг зөрчил түгээмэл байна. Үүнээс шалтгаалж мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайлан дахь зардлын ангилал үнэн зөв тайлагнагдаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавын дагуу зардлыг санхүүжүүлэх, бүртгэж тайлагнах, төсвийг бодитой төлөвлөх, шаардлагатай тохиолдолд төсвийн тухай хууль, журмын дагуу төсөвт зохицуулалт хийх зэрэг шийдлүүдэд нягтлан бодогчдыг чиглүүлж, арга зүйгээр хангаж ажиллах.

4.4.3 Төсөв тодотгон баталсан тогтоол шийдвэртэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Цэцэг сумын 2021 оны төсвийн тодотголыг сумын ИТХ-ын 08 дугаар сарын 10-ны өдрийн 23 дугаар тогтоолоор баталсан боловч нэгтгэн товчоолж орлого, зардлын дүнг батлаагүй, нийт зардлын дүн нь санхүүжүүлэх эх үүсвэрийн дүнтэй зөрүүтэй, зарим зардлын дүнг тогтоолд тусгаагүй зэрэг зөрчил байна.

Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журмын 2 дугаар хавсралтаарх сум, дүүргийн төсвийн төслийг батлах маягтын дагуу төсөв батлах.

4.4.4 Татварын орлогын төлөвлөлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Татварын орлогын ногдуулалт, төлөвлөлт нь бодит тоон мэдээлэл, тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөгдсөн эсэхэд санхүүгийн албанаас хяналт хэрэгжүүлээгүй, орон нутгийн суурь орлогыг нэмэгдүүлэх боломжийг эрэлхийлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйлд заасан төсвийн төсөл боловсруулахад тавигдах шаардлага, удирдамжид нийцүүлэн бодит тоон мэдээлэл, судалгаанд үндэслэн төлөвлөж болохуйц зарим нэр төрлийн татварын орлогыг зохистой төлөвлөхөд чиглүүлж, хяналт хэрэгжүүлж ажиллах.

4.4.5 ЗДТГ-ын санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Шатахууны зарцуулалтад хэрэгжүүлэх дотоод хяналт, цахим и-баримт болон анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангаагүй, он дамжсан, насжилт өндөртэй, эзэн холбогдогч нь тодорхойгүй авлагыг тодорхойлж барагдуулаагүй зэрэг 110.8 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

Зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлд заасан нягтлан бодогчийн эрх, үүргийн дагуу нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах, санхүүгийн сахилга хариуцлагыг сайжруулж дээрх зөрчлийг арилгах, цаашид давтан гаргахгүй ажиллах.

4.4.6 ИТХ-ын санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Он дамжсан, насжилт өндөртэй 0.5 сая төгрөгийн авлага барагдуулаагүй байна.

Зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан нягтлан бодогчийн эрх, үүргийн дагуу он дамжсан, насжилт өндөртэй авлагыг барагдуулж ажиллах

4.4.7 Соёлын төвийн санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Шатахууны зардлыг зориулалт бус зардлын эдийн засгийн ангиллаас гүйлгэн зарцуулсан, И-баримтын бүрдэл хангалтгүй, батлагдсан орон тооноос илүү орон тоотой үйл ажиллагаа явуулсан

Зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.9, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлд заасан нягтлан бодогчийн эрх, үүргийн дагуу нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах, санхүүгийн сахилга хариуцлагыг сайжруулж дээрх зөрчлийг арилгах, цаашид давтан гаргахгүй ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дүгээр сарын 3-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

ТТЗ болон түүвэрт хамрагдсан байгууллагын алдаа зөрчлийн нэгтгэл Хүснэгт-6
/сая. төгрөгөөр/

д/д	байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ТТЗахирагч	4	197.9					1	0.0	3	197.9
2	Цэцэг ЗДТГ	5	220.2	2	100.2	2	9.2			1	110.8
3	Цэцэг ИТХ	3	1.1	1		1	0.6			1	0.5
4	Цэцэг соёлын төв	1	0.0							1	0.0
5	Цэцэг ОНХС	3	116.5	1	5.2	1	20.0	1	91.3		
6	Цэцэг СХС	3	165.6	1	20.4			1	145.2	1	0.0
	Дүн	19	701.3	5	125.8	4	29.8	3	236.5	7	309.2

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Х.БОЛДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР: А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АУДИТОР: Б.ДОЛЖИНЖАВ

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Х.БОЛДБААТАР
АУДИТЫН МЕНЕЖЕР: А.ЦЭЦЭГСҮРЭН
ТАЙЛАНГ БИЧСЭН:
АУДИТОР: Б.ДОЛЖИНЖАВ



ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 03 сарын 24 өдөр

Дугаар 78/A2170428

Ховд

ХОА-2022/14/НА/СТА-ТТЗ

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цэцэг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс 2 иргэнд эргэн төлөх нөхцөлтэй нийт 20.0 сая төгрөгийн зээл олгож, сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.5-д "Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг зээл олгох, санхүүгийн үр дагавар бүхий баталгаа гаргах, хохирлыг нөхөн төлөх үүрэг авах арга хэмжээнд зарцуулахыг хориглоно", Сангийн сайдын 2021 оны 81 дүгээр тушаалаар батлагдсан орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 4 дүгээр зүйл "ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх чиг үүрэг, үндсэн нөхцөл"-ийн 4.7.3-д "Нийтийн эрх ашигт нийцээгүй үйл ажиллагааг ОНХС-аас санхүүжүүлэхгүй, зөвшөөрөхгүй" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Дээрх зөрчилтэй холбоотой 20000000 /Хорин сая төгрөг /-ийг Цэцэг сумын орон нутгийн хөгжлийн сангийн 100161952400 тоот дансанд 2022 оны 05 дугаар сарын 15-ны дотор төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2022 оны 05 дугаар сарын 30-ны дотор Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Цэцэг сумын Засаг дарга Ж.Мөнхзориг, санхүү албаны дарга Т.Сувд-Эрдэнэ, ОНХС хариуцсан нягтлан бодогч Д.Заяа нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЦЭЦЭГСҮРЭН

АУДИТОР

Б.ДОЛЖИНЖАВ

1 Монгол Улс, Ховд аймаг, Жаргалант сум, Цамбагарав баг, Засаг даргын Тамгын газрын байр, 3 давхар Утас: 70433061

001050142



ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 сарын 24 өдөр

Дугаар 51 А/217-0428

Ховд

ХОА-2022/14/НА/СТА-ТТЗ

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цэцэг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар сумын орон нутгийн хөгжлийн санг түүвэрт хамруулан хянахад орон нутгийн хөгжлийн сангаас 5 багийн 5 өрхөд гэр олгоход 17.5 сая, иргэдээс санал аваагүй хөтөлбөр арга хэмжээ буюу иргэдийн төлөөлөгч нарыг чадавхжуулах зардалд 10.0 сая, өвс тэжээлийн фонд бэлтгэхэд 20.0 сая, Ковид-19 вирусын тархалт, дэгдэлтээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 9.0 сая, түүнчлэн хөшөөт багийн барилга байгууламжийн байр ашиглалтын тогтмол зардал, гэрээт ажилчдын цалин хөлсний зардалд буюу урсгал зардлыг санхүүжүүлэхэд 34.8 сая, нийт 91.3 сая төгрөгийг журам зөрчин төлөвлөж зарцуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.5-д “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээнд зарцуулахыг хориглоно”, Сангийн сайдын 2021 оны 81 дүгээр тушаалаар батлагдсан орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 4 дүгээр зүйл “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх чиг үүрэг, үндсэн нөхцөл”-ийн 4.7.6-д “аливаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд олгох буцалтгүй тусламж, дэмжлэг, тэтгэмж, урамшууллыг ОНХС-аас санхүүжүүлэхгүй, зөвшөөрөхгүй” гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

3. Дээрх зөрчлийг таслан зогсоож биелэлтийг 2022 оны 05 дугаар сарын 25-ны дотор Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт² ирүүлэх.

4. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цэцэг сумын Засаг дарга Ж.Мөнхзориг, санхүү албаны дарга Т.Сувд-Эрдэнэ, ОНХС хариуцсан нягтлан бодогч Д.Заяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЦЭЦЭГСҮРЭН

АУДИТОР

Б.ДОЛЖИНЖАВ





2022 оны 05 сарын 24 өдөр

Дугаар 52 А/2170428

Ховд

ХОА-2022/14/НА-СТА-ТТЗ

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цэцэг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар сум хөгжүүлэх сангийн тайланг түүвэрт хамруулан хянахад 145.2 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн авлагад алданги тооцоогүй, зээл авсан иргэдтэй тооцоо нийлж зээлийн үлдэгдлийг баталгаажуулаагүй, түүнчлэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас сум хөгжүүлэх сангийн зээл нь тус сангийн зорилго, журамд нийцэж буй эсэхэд хяналт хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагааны журам, зээлийн гэрээний үүргийн холбогдох заалт, эргэн төлөлтийн хуваарь, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "Төсвийн шууд захирагч нь төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлд заасан нягтлан бодогчийн эрх, үүрэг, хариуцлагатай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хугацаа хэтэрсэн зээлийн авлагад алданги тооцож, зээл авсан иргэн, хуулийн этгээдтэй нэг бүрчлэн тооцоо нийлэх, түүнчлэн хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулж, тайланг 2022 оны 05 дугаар сарын 25-ны дотор Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт³ ирүүлэх.

5

¹ Монгол Улс, Ховд аймаг, Жаргалант сум, Цамбагарав баг, Засаг даргын Тамгын газрын байр, 3 давхар Утас: 70433061

• 021040016

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цэцэг сумын Засаг дарга Ж.Мөнхзориг, санхүү албаны дарга Т.Сувд-Эрдэнэ, СХС хариуцсан нягтлан бодогч Д.Заяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЦЭЦЭГСҮРЭН

АУДИТОР

Б.ДОЛЖИНЖАВ





ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 сарын 24 өдөр

Дугаар 50 А/2170428

Ховд

ХОА-2022/14/НА-СТА-ТТЗ

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цэцэг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн тайланд аудит хийхэд шилэн дансны цахим мэдээллийн системд төсвийн төвлөрүүлэн захирагчийн оруулбал зохих зарим мэдээллийг цаг хугацаанд нь иж бүрэн, үнэн зөв мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны хухай хуулийн 4, 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам"-д тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Дээрх зөрчлийг таслан зогсоож биелэлтийг 2022 оны 05 дугаар сарын 25-ны дотор Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цэцэг сумын Засаг дарга Ж.Мөнхзориг, санхүү албаны дарга Т.Сувд-Эрдэнэ, ОНХС, СХС хариуцсан нягтлан бодогч Д.Заяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР А.ЦЭЦЭГСҮРЭН
АУДИТОР Б.ДОЛЖИНЖАВ



2

¹ Монгол Улс, Ховд аймаг, Жаргалант сум, Цамбагарав баг, Засаг даргын Тамгын газрын байр, 3 давхар Утас: 70433061

• 021040010